



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/68

Жаргалтхаан

**Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн үзлэг явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны А/88 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн үзлэг оношилгоог 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион явуулсугай.

2. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураан авах, үзлэг зохион явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбат - Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: А.Оюунтунгалаг – Татварын улсын байцаагч

Н.Ууганбаяр – Газрын даамал

Н.Түвшинжаргал – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Б.Мөнх-Эрдэнэ - Замын цагдаагийн зохицуулагч

Д.Энхболд – 1 дүгээр багийн Засаг дарга

Э.Аранжал – 2 дугаар багийн Засаг дарга

М.Өсөхжаргал – 3 дугаар багийн Засаг дарга

Б.Мэндбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Жаргал – 5 дугаар багийн Засаг дарга

3. Авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэн гаргах, тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд авто тээврийн үзлэгийн зар хүргэж бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт, авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгсэлд хяналт тавьж ажиллахыг Замын цагдаагийн зохицуулагч (Б.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, зам ашиглалтын төлбөрөө төлөөгүй татвар төлөгчдийн өрийг барагдуулж ажиллахыг Татварын Улсын байцаагч (А.Оюунтунгалаг) –д даалгасугай.

232401159

2.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Ганбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ